

**МОНГОЛБАНК, БИЧИЛ САНХҮҮГИЙН ХӨГЖЛИЙН САН, БСШУСЯ-
НЫ ХАРЬЯА НАСАН ТУРШИЙН БОЛОВСРОЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН
ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ САНАМЖ БИЧИГ**

2017 оны 11 дүгээр
сарын 09-ний өдөр

Улаанбаатар
хот

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү хамтын ажиллагааны санмж бичиг (цаашид “Санамж бичиг” гэх)-ийг нэг талаас Монголбанк /цаашид “МБ” гэх/, нөгөө талаас Бичил Санхүүгийн хөгжлийн сан / цаашид “БСХС” гэх / болон БСШУС-ын яамны харьяа Насан туршийн үндэсний боловсролын төв / цаашид “НТБҮТ” гэх / дор дурдсан асуудлаар харилцан тохиролцон үйлдэв.
- 1.2 Хамтын ажиллагааны санамж бичгийн зорилго нь МБ, БСХС, НТБҮТ (цаашид “талууд” гэх) “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд хөдөө орон нутгийн иргэдийн санхүүгийн мэдлэг дээшлүүлэх, санхүүгийн зохистой шийдвэр гаргах чадвар нэмэгдэх, урт хугацаатай хуримтлал болон санхүүгийн хөрөнгө оруулалт нэмэгдүүлэх, санхүү, банкны системд итгэх олон нийтийн итгэлийг дээшлүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагаанд хамтран оролцох, хамтын ажиллагааны зарчим, зохицуулалтын үйл ажиллагааны хүрээг нэгтгэн чиглүүлэхэд оршино.
- 1.3 Хамтын ажиллагаа нь хуулиар хориглоогүй асуудалд ил тод нээлттэй байх, хамтын ажиллагааны үр дүнг нэгтгэн хэлэлцэх, харилцан дэмжлэг үзүүлэх зарчимд тулгуурлан Төв банкны /Монголбанк/-ны тухай хууль, Бичил санхүүгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны дүрэм, Боловсролын тухай хууль, Монгол Улсын хууль тогтоомжийн заалтыг удирдлага болгоно.

ХОЁР. ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ЧИГЛЭЛ

“Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийг дэмжих талаар хамтын ажиллагаа нь дараах чиглэлтэй байна.

- 2.1 Хөтөлбөрийн хүрээнд үндэсний хэмжээнд сургагч багш нарыг бэлтгэх, тэднийг чадавхжуулах;
- 2.2 Хамтарсан эрдэм шинжилгээ, олон талт сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах;
- 2.3 Талууд хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулсан, хэрэгжүүлсэн ажлын талаарх мэдээллийг тус тусын вэб сайтад байршуулж, тогтмол шинэчилж байх;
- 2.4 Санхүүгийн мэдлэг олгох гарын авлага, багшийн ном, орон нутгийн иргэдэд сургалт явуулахад ашиглагдах материал, видео хичээл болон бусад цаг үеийн хэрэглэгдэхүүн боловсруулах;
- 2.5 Санхүүгийн боловсролын чиглэлээр туршлага судлах дотоодын болон олон улсын сургалтанд хамрагдах.

ГУРАВ. САНАМЖ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ

3.1. Талууд энэхүү санамж бичигт заасан үүргийг биелүүлж, бүрэн хүлээн ажиллана.

3.2. Талууд энэхүү санамж бичгээр харилцан тохиролцоогүй болон нарийвчилсан ажилд хамтран ажиллах тохиолдолд гэрээ байгуулж болно.

3.3. Хамтран гүйцэтгэх ажил үүргийг талууд тухайн тохиолдолд нарийвчлан тохиролцох бөгөөд тухайн ажил гүйцэтгэхэд талуудын хоорондын харилцаанд энэхүү санамжийг баримтална.

3.4. Энэхүү санамж бичгийн хугацаа дуусахад түүнийг сунгах буюу дахин шинээр байгуулж болно.

3.5. Энэхүү санамж бичигт гарын үсэг зурж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болох бөгөөд санамж бичигт өөрчлөлт оруулах, шинэчлэх талаар талууд санал гаргаагүй тохиолдолд 3 жилийн хугацаанд хүчинтэй байна.

3.6. Санамж бичгийг Монгол хэлээр гурван хувь үйлдэж, тал тус бүр нэг хувийг хадгалав.



БИЧИЛ САНХҮҮГИЙН
ХӨГЖЛИЙН САНГИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



БСШУСЯ-НЫ ХАРЬЯА НАСАН
ТУРШИЙН БОЛОВСРОЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРАЛ

